

ЭХ ТҮҮХЭЭН ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛСЭН ИХ ЭРДЭМТЭН ЧУЛУУНЫ ДАЛАЙ

*Л.Хайсандай**

*Эрдэм номын андууд аа!
Эрхэмсэг хатагтай ноёд оо!
Та бүхний энэ өдрийн амрыг айлдъя.*

Эх дэлхийн соёлт хүмүүн төрөлхтний нэгээхэн хэсэг нэн эртний түүх, соёлын өлгий болсон монгол нутаг, монгол түмний төрүүлсэн тэр гайхамшигт, тэр тэнгэрлэг алдар суут хүмүүсийн нэг нь яахын аргагүй эх түүхээн эрхэмлэн дээдэлсэн их эрдэмтэн Чулууны Далай мөнөөс мөн билээ.

Чухамхүү Чулууны Далай академичийн амьдралын алтан шар зам, өөрийнх нь түүх намтрын эхлэл, эрдэм номынх нь гараа чухамдаа алс баруун хязгаар нутаг-Ховд аймгийн Зэрэг сумаас эхтэй. Тэнд тэрбээр төрж өссөн. Тэнд тэрбээр бичиг үсэгт суралцсан. Тэндээс тэрбээр эрдэм ном сурахаар алсын замд мордсон.

1950 оны намар тэрбээр Улаанбаатар нийслэл хотдоо ирж улсынхаа ууган ганц их сургуульд элсэн орж 2 жил суралцжээ. 1952 онд хөдөөгийн энэ хөвүүнд аз тохиож, Өрнө, Дорнодод нэр алдар нь мандсан Бээжингийн их сургуульд сурах сайхан боломж олджээ. Тэндээ 6 жилийн турш суралцаж, амжилттай төгсөж дээд боловсролтой, түүхчийн мэргэжлийн дипломтой, бас хятад хэлийг төгс эзэмшсэн шинэ залуу боловсон хүчин болоод эх орондоо буцаж ирсэн байна.

1958 оны намар эхлээд МУИС-ийн түүхийн багшаар томилогдон ажиллажээ. Хоёр жилийн дараа 1960 оноос ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар дэвшин ажилласан байна. Тэр цагаас хойш олон арван жил өнгөрөхөд 2 удаа л БНХАУ дахь Монгол Улсын ЭСЯ-нд хариуцлагатай албыг томилолтоор хашжээ. Бусад бүх он жилийг (40 гаруй жилийг) ШУА-ийн системийн байгууллагуудад удирдах ажлыг тасралтгүй хийж ирсэн юм. Энэ бүх хугацаанд тэрбээр монголын түүхийн салбарт судлагаа шинжилгээний нөр их хөдөлмөр, оюун ухаан мэдлэг чадвараа дайчлан ажиллаж олон арван бүтээл туурвисныг бид сайн мэднэ. Түүний бичиж туурвисан “Хамаг Монгол улс”, “Их Монгол улс”, “Монголын Юань гүрэн” хэмээх гурамссан бүтээлийг онцлон дурдах ёстой. Эдгээр бүтээл нь Монголын түүхийн хамгийн их бахархалтай бөгөөд нэн ээдрээ төвөгтэй, хамгийн бага судлагдсан буюу огт судлагдаагүй үе буюу XII зуунаас хойших 300 гаруй жилийн түүхийг хамран цогц байдлаар системчилж, хятад, орос, япон, англи, араб, манж хэлээрх эртний эх сурвалж, судлагааны олон мянган маш ховор чухал материалуудыг нягт нямбай судлан ашиглаж бичсэн Монголын түүх судлалын тулгуур бүтээлүүд болсон юм.

*Л.Хайсандай - ОУСХ-гийн захирал, доктор (Sc.D), профессор

“Хамаг Монгол Улс (1101-1206)” УБ., 1996 бүтээлд Язгуурын Монголоос бүрэлдсэн гол улс XI зууны дунд үеэс байгуулагдсан, гурван голоор савласан тэрхүү язгуурын улс нь XI зууны сүүлч XII зууны эхэн буюу Байшинхор догшин, Тумбиной сэцэний үед Хамаг Монгол нэртэйгээр түүхэнд тодорхой болон гарч ирсэн гэж үзсэн, Хамаг Монгол улс байгуулагдсан он цагийн эхлэлийг 1101 оноос гэж тодруулсан. Түүнийгээ түүхийн бусад сурвалж материалаар тодотгон нотолсон, Хамаг Монгол улсын задрал, сэргэлтийг сурвалжаар бодитой харуулж чадсан, түүхийн балархай үеийг бүрэн гүйцэд тодруулж, түүхэн он цаг, эрдэмтдийн үзэл бодлын зөрүүг нэг мөр болгон эцэслэн шийдвэрлэсэн.

Академич Ч.Далай энэ бүтээлээрээ монголчууд нэгдмэл улсын бүрэлдэхүүнд амьдрах хувь тавилан нөхцөл бололцоогоор ерөнхийдөө хангагдсан, аж ахуй, нийгэм, улс төр, соёл, хэл, ёс заншлаараа нэгдмэл Монгол улс бүрэлдэн тогтох, түүхэн үйл явц үндэс суурь нь Хамаг Монгол улсын үед тавигдсан гэсэн хамгийн үнэ цэнэтэй дүгнэлт хийсэн юм.

“Их Монгол Улс (1206-1260)” УБ., 1994 бүтээлд Их Монгол улс байгуулагдах урьдчилсан нөхцөл, Их Монгол улс байгуулагдсан, Чингис хааны аян дайн ба түүний нас барсан, Их Монгол улсын нийгэм, эдийн засаг, Өгөдэй хааны шинэчлэл, Гүюг, Мөнхийн хаанчлалын үе, Их Монгол улсын соёл, шашин, зан заншил зэрэг өргөн хүрээтэй сэдвийг хамруулан авч үзсэн юм.

Академич Ч.Далайн энэхүү нэгэн сэдэвт бүтээлийн чиглэлээр урьд өмнө Монголд судалгаа нэлээд хийгдэж, энэ үеийг “Монголд байгуулагдсан нэгдсэн төр”, “Нэгдсэн Монгол улс”, “Монголын эзэнт улс”, “Монгол гүрэн” гэх мэтээр бичиж ирсэн. Энэ бүхнийг харьцуулан судлаад “Их Монгол улс” гэдэг нэрийг анх хэрэглэсэн юм. Энэ нь Чингис хаан улсаа ийн нэрлэж төрийнхөө Хасвуу тамганд “Их Монгол улсын далай хаан” гэж бичсэн үгүйсгэшгүй үнэнээр энэ үеийн Монгол Улсыг “Их Монгол улс” хэмээн нэрлэсэн.

Ч.Далай энэ нэрийг анх удаа түүх бичлэг, Монголын түүхийн шинжлэх ухаанд оруулан хэрэглэснээр өдгөөгийн монголч эрдэмтэд түүний санаа дүгнэлтийг хүлээн зөвшөөрч өөрсдийн судалгаанд энэ нэр томъёог ёсчилон хэрэглэх болсон юм.

Чингис хаан бүх Монгол овогтныг нэгтгэж Их Монгол улсыг үндэслэн байгуулсан нь Монголын түүхэнд нэн их дэвшилтэт үйл хэрэг болсон. Тийм ч учраас ертөнцийг донсолгож, сүр хүчээ үзүүлж, нэр дуурсгасан Чингис тэргүүтэй Их Монгол улсын далай хаадын үйл ажиллагааг жинхэнэ үнэний шалгуураар үзэл суртлаас ангид зөвхөн судлаачийн байр сууринаас задлан шинжилж нэгтгэн дүгнэсэн бүтээл болсноороо цоо шинэ бөгөөд судалгааны ихээхэн ач холбогдолтой юм.

“Монголын түүх (1260-1388)” УБ., 1992 нэгэн сэдэвт бүтээлд Юан гүрнийг байгуулсан, Юан гүрний үеийн Монголын засаг төрийн байдал, гадаад бодлого, аж ахуй, нийгмийн байгууламж, Юан гүрэн мөхөж, Монгол улсын төв эх нутагтаа эргэн шилжсэн болон Юан гүрэн мөхсөний дараах Монгол, Хятадын харилцаа зэрэг асуудлыг хөндөн авч үзжээ.

Энэ чиглэлээр урьд болон уг бүтээлээс хойш тусгайлан ганц сэдэвт бүтээл зориглон туурвисан эрдэмтэн мэргэд дотоод, гадаадад өнөө хэр гараагүй байна. Энэ нь уг сэдвийн нарийн ээдрээтэй, эгзэгтэйг харуулахын дээр нөгөө талаас энэ бүтээлээс илүү гарахаар ном бичигдэхгүй гэдгийг ухаант мэргэд аль хэдийн тунгаасных буй за.

Энэ зохиол нь Монголын байлдан дагуулагчид Хятад зэрэг Азийн олон улсыг байлдан эзэлж эрхэндээ оруулж захиран дарангуйлж, харь улсын нутагт нийсэллэн сууж байсан хэдий боловч Монголын ард түмэн угуул нутагтаа амьдарч, аж төрөн улс гэрээ байгуулан төвхнүүлж байсныг бодит үнэнд нийцүүлэн нягтлан судалсан цоо шинэ бүтээл болсон юм.

Ч.Далайн энэ бүтээл нь өмнөх хоёр ботийн нэгэн адил их дээд сургуулийн түүхийн салбарын багш оюутнууд болон Монголын түүх сонирхогч хэн бүхний гарын авлага болон ашиглагдсаар байгаа төдийгүй Монголын түүхийн шинэ 5 ботийн үндсэн хэрэглэгдэхүүн болон ашиглагдсан үнэт бүтээлүүд юм.

Монголын түүхийн салшгүй хэсэг болсон баруун Монголын ард түмний түүхийг дагнан авч үзэж бичсэн **“Ойрад Монголын түүх”** УБ., 2002 бүтээлд Ойрадын гарал үүсэл ба Ойрадын чуулган байгуулагдсан, Эсэн хаан ба түүний дараах үеийн Ойрадын холбооны төрх байдал, Монгол-Ойрадын цаазыг батлан гаргаж хэрэгжүүлсэн тухай, Баатар хунтайжийн үеийн Ойрад болон Зүүнгарын хаант улс байгуулагдсан, Ойрадын хаант улс ба Халхын хаант улсын харилцаа, Цэвээнравдан, Галданцэрэн нарын үеийн Зүүнгарын хаант улс, Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн Галдан бошготын тэмцэл, Зүүнгарын хаант улсад хямрал үүсч, Манжийн довтолгоо эхэлсэн, Баруун Монголын ард түмэн тусгаар тогтнолоо хамгаалан Манжийн түрэмгийлэгчдийн эсрэг эрслэн босч тэмцсэн зэрэг гол гол түүхэн үйл явдлуудыг тодруулан үнэлэлт дүгнэлт өгчээ.

Урьд өмнө харьцангуй бага судлагдаж ирсэн Ойрад Монголын түүхийг иж бүрнээр авч үзсэн академич Ч.Далайн энэ судалгаа нь Монголын түүхийн бүдэг асуудлыг олон талаар тодруулж, түүхийг үзэх шинэ үзэл бодол өнөөгийн өндөрлөгөөс хандаж шинэ санаа дүгнэлтийг дэвшүүлж чадсан цоо шинэ, үнэ цэнэтэй бүтээл болсон юм.

Судалгааны эргэлтэнд орж байгаагүй дотоод гадаадын сурвалж материалуудад тулгуурлан дэвшүүлсэн шинэ санаа дүгнэлтүүд, нэр томьёо зэрэг нь эдүгээ Монголын түүх судлаачдын бүтээл, их дээд сургуулийн сургалтын программд тусгалаа олж, практикт нэвтрэн нэгэнт олны хүртээл болоод байгаа юм.

Ч.Далай “Их Монгол Улс” УБ., 2006 нэгэн сэдэвт бүтээл нь Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан энэ бүтээлдээ VII зууны үеэс Гурван голын сав газраар монгол угсаатны овог аймгууд нүүдэллэн ирж, улмаар Хамаг Монгол улсыг байгуулсан. Хожим Их Монгол улсыг байгуулахад Хамаг Монгол улс нь төрт улс бүрэлдэн бий болох гол цөм болсон. Энэ үеэс монголчууд хүн төрөлхтний нийгэм-түүхийн хөгжлийн бодит зүй тогтлын голдиролд орсон. Улмаар дэлхийд нэр нөлөөтэй, дорно өрнийг холбосон, өөрийн гэсэн бие даасан гадаад харилцаатай, хэний ч эрхшээлд биш,

цэрэгжсэн хүчирхэг улс болж Монголын төрт ёсны түүхийг цоо шинээр урагшлуулсан. Их Монгол улс өсөлт хөгжлийн явцад 1250-иад оны үеэс дэлхийн эзэнт гүрний хэмжээнд хүрч, улмаар Юан улсаар төвлөрсөн Алтан Ордны улс, Цагаадайн улс, Эл хаадын улс гэсэн холбооны улсын хэлбэртэй, дэлхийн хуурай газрын тал хувийг эзэгнэсэн, хүн амын гуравны нэгийг багтаасан, нүүдлийн хийгээд суурьшмал соёл иргэншлийг хосолсон, тухайн үеийн шашны бүх урсгалыг эн тэнцүү үздэг, хэмжээлшгүй их эзэнт гүрэн болж чадсаныг шинжлэх ухааны үндэслэлтэй яруу тод нотлон харуулжээ.

Энэ бүтээл нь Монголын түүх бичлэг ялангуяа XII-XIV зууны үеийн түүхийг бүхэлд нь хамарсан, уг үеийн түүхийн олон балархай асуудлуудыг нэг мөр болгон тодотгож, урд өмнөх судалгааг олон шинэ санаа дүгнэлтээр баяжуулж, дундад зууны түүх бичлэгийг шинэ шатанд гаргасан томоохон бүтээл юм.

2006 онд дэлхийн хэмжээнд тэмдэглэсэн Их Монгол Улсын 800 жилийн ой академич Далайн судалгааны эргэлтэд анх оруулсан тэр л нэр томъёонд үндэслэнхээс үзэхэд ч энэ хүн Монгол Улсын дундад зууны түүхийн судалгаанд даацтай хувь нэмэр оруулсан нэртэй эрдэмтэн болох нь тод томруун харагддаг.

Академич Ч.Далайн эдгээр бүтээл нь бичлэгийн хувьд энгийн ойлгомжтой үг хэллэг, найруулгаар бичигдсэн, дотоод гадаадын эрдэмтэд судлаачид, сурган хүмүүжүүлэгчид, оюутнууд, түүх сонирхогч олон түмний дунд өргөн ашиглагдаж, Монголын эх түүхийн боловсролд ч томоохон хувь нэмэр оруулсаар байгаа юм.

Академич Ч. Далай эрдэм судлалын гараагаа дөнгөж эхлэж байсан бүүр 1959 онд “Монголын бөө мөргөлийн түүх” хэмээх нэн сонирхолтой нэгэн сэдэвт зохиол бичиж нийтлүүлсэн нь монголын ба гадаадын эрдэмтэн судлаачдын анхаарлыг их татжээ. Тэгээд ч энэ бүтээл нь БНХАУ-д хятад хэлээр, франц, герман, япон хэлээр тухайн орнуудад орчуулагдан хэвлэгджээ. Түүнчлэн Ч.Далайн бичсэн “XIII- XIV зууны Монгол”, “Монгол-Хятадын харилцаа” хэмээх бүтээлүүд нь орос, чех хэлээр нийтлэгдсэн байна. Ч.Далай Ази судлалын чиглэлээр 3 дэвтэр бүтээл бичсэн бөгөөд “Монгол-Солонгосын эртний харилцаа”, “Монгол-Японы эртний түүхэн харилцаа”, “Монгол дахь хятад судлал” хэмээх нэгэн сэдэвт бэсрэгхэн зохиолууд нь дорнодахины судлалд чухал хувь нэмэр оруулсан. Тэрээр 1970 онд түүхийн ухааны дэд доктор, 1986 онд түүхийн шинжлэх ухааны докторын зэргийг “Юань гүрний Монгол”, “Монгол-Хятадын харилцаа (1949-1984)” сэдвүүдээр тус тус амжилттай хамгаалсан байна. Монголын түүхийн болон орчин үеийн асуудлаар, Хятад, Япон, Солонгос судлалаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг багцаалан тооцоолж үзэхүл 240 орчим болж буй бөгөөд 60 гаруй нь гадаад хэлүүд дээр нийтлэгдсэн байх юм. Барагцаалвал 26 хүний боловсролын ба шинжлэх ухааны докторын ажлыг удирдаж амжилттай хамгаалуулсны 12 хүн нь Орос, Хятад, Япон, Солонгос, Чех улсын иргэд байх жишээтэй. Чингээд үзэхэд ямар аугаа их бүтээлч, эрдэм ухаантай, эгэл жирийн атлаа асар өндөр нэр хүндтэй гайхамшигтай хүн байсан нь аяндаа мэдрэгддэг юм. Гэхдээ академич Ч.Далай агсны зам шулуун дардан байгаагүй. Тэрбээр

1970-1980-аад оны захиргаадлын үед цөөн хэдэн хүний атаа жөтөө, өчүүхэн явцуу эрх ашиг давамгайлж “Ч.Далай бол марксист-леннист онолын мэдлэггүй. Өөрийн зохиол бүтээлд энэхүү онол сургаалийн үзэл санааг тусгадаггүй. Зөвхөн Хятадын маоист үзэл сургаалд автагдсан этгээд...” гэх мэтийн гүтгэлэг, хардлага сэрдлэгэнд өртөж, албан ажлаасаа хэсэг зуур авч халагдаж, байцаагдаж, зохиол бүтээлээ хураалгаж хэвлэн нийтлүүлэхээ хориулж, тэр ч байтугай галдан шатаалгаж, 10 шахам жилийн турш гадагш хил нэвтрэх эрхээ хасуулж байсан хатуу шийтгэл, харамсам гашуун үйл явдалтай учирч байсан удаатай. Энэ тухай их эрдэмтэн өөрөө өгүүлэхдээ: “За энэ ч яах вэ. Тухайн цаг үеийн ойр зуурын бодолтой ганц нэг хүний явууллага юм даа. Харин энэ үе бол миний хувьд хамгийн их бүтээлч үе байна. Магад ч үгүй доктор, профессор, улмаар академич, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн болох зам үүдийг нээж өгсөн ч юм билүү...” гэсэн шигээ огтхон ч тоосон шинжгүй, эрдэм бүтээлээ туурвисаар байж билээ. Үнэхээр ч түүний хэлснээр бүх юмны сайн сайхан үүд нээгдэж, бүх юм ёсоор болсон байдаг. Энэ бол эрдэмтэн хүний замнал, гайхамшигт хувь тавилан мөн ажгуу.

Ч.Далай академич өөрийн хамгийн томоохон гол суурь бүтээлээ 1990-2000-аад оны үед бичиж туурвисан байдаг. Энэ үе бол шинэчлэл өөрчлөлтийн цаг үе байсан. Харин харамсалтай нь энэ үед академич, ШУГЗ Ч.Далайд бас нэг ёсны хэлмэгдүүлэлт маягийн юм болсныг хэлэх хэрэгтэй. Түүний туурвисан гурамссан зохиол бүтээлээр нь Монгол Улсын төрийн соёрхолд 2005, 2007 онуудад 2 удаа нэрийг нь дэвшүүлж ШУА-ийн их, бага чуулганаар батлуулан дээш нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт өргөн мэдүүлэхэд “голын усанд чулуу хаясан” мэт алдарсан юм. Бас 2009 оны хавар “Монгол Улсын хөдөлмөрийн баатар” цол хүртээхээр тус хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөс албан ёсоор санал оруулахад ШУА-ийн тэргүүлэгчид, тухайлан одоогийн ерөнхийлөгч, тэр үеийн дэд ерөнхийлөгч академич Б.Энхтүвшин гуай (урьд нь ч бас тууштай дэмжиж байсан) өөрөө биечлэн хичээн хүчин зүтгэж хөөцөлдсөн авч бүүр дээрээ очоод бас л таг чимээгүй, хариу ч үгүй болсон юмдаг. Тэрнээс хойш нэг их удсангүй академич маань таалал төгсч бурхны оронд заларсан юм даа.

Ийм л түүх, тийм л хувь тавилан тохиож байсан. Гэхдээ энэ аугаа их эрдэмтний нэр алдар, эрдэм номын бүтээл туурвил нь мартагдсан ч үгүй, харин ч улам дэвжин дээшилж, мөнхрөн бишрэгдсээр байнам.

**Эрдмийн их үйлсийн эрхэм дээд шүтээн
ном дор мөргөмү.**